Дөчдүгззр зүйл

1. Энэхүү Гэрээнд өөр журам заагаагүй бол а сран хамгаалах, харгалзан дэмжих асуудлыг тогтоох болон хүчингүй болгохдоо Эсрvулагчийг харьяалах Хэлэлцэн Тохирогч Зтгзздийн байгvуллага шийдзэрлэнэ.

2. Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн байгууллагаас еөрийг иргэдэд асран хамгаалах, харгалзан дэмжих асуудлыг тогтоох болон хүчингүй болгох тухай гаргасан шийдвэрийг Хэлзлыэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт хүлээн зөвшөөрч хүчин төгөлдөрт тооцно*

дочин нзгдүгээр зүйл

1. Хзрэв Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн нутаг дэвсгэрт Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгзэдийн харьяатын оршин суугаа,эд хөрөнгө нь тэнд байгаа үед тэрхүү Хэлэлизн Тохирсгч Этгээ - дийн иргэний ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай бол нутаг дэвсгэрт нь тэр иргэн байгаа Хэлзлцэн Тохирогч Этгээдийн эрх бүхий оайгууллага Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт нэн даруй мэдэгдэх ёстой.

2. Хойшлуулшгүй шийдвэрлэх тохиолдолд зрх бүхий байгууллага өөрийн улсын дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу түр арга хэмжээг авч тэр тухайгаа энэ зүйлийн I дэх ангид зааснаар дипломат төлеелегчийн буюу консулыи газарт яаралтай мэдэгдэж байка. Түр арга хзмжээ нь Хэлэлцзн Тохирогч нөгөө Этгээдийн эрх бүхий байгууллага еөр шийдвэр гаргаж тэр тухайгаа түр арга хэмжээ авсан байгууллагад мздзгдэх хүртэл хүчин төгөлдөр байна.

Дөчии хоёрдугаар зүйл

I. Хэрэв асруулагч нь Хэлэлцэн Тохирогч нэг Зтгзэдийн ну?аг дэвсгэрт байнга буюу түр оршин суугаа үед энзхүү Гэрээний 40 дүгээр зүйлийн I дэх ангид заасан Хэлэлцэн